

2025 оны 01 сарын 07-ны өдөр

№ 2025/1

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй  
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягийн нэгдмэл сонирхолтой этгээд болох хүү Г.Хасбазарт 300,000,000 (гурван зуун сая) төгрөгийн шугамын зээлийн эрхийг дараах нөхцөлөөр нээхийг зөвшөөрсүгэй.

|                       |                                                |
|-----------------------|------------------------------------------------|
| Зээлийн хүү           | 28.8% /жилийн /                                |
| Зээлийн хугацаа       | 12 сар                                         |
| Зээл олголтын шимтгэл | 1%                                             |
| Эргэн төлөх нөхцөл    | Сар бүр хүү, хугацааны эцэст үндсэн зээл төлөх |

2. Зээлийн гэрээ байгуулсантай холбогдуулан зээлийн шугамын эрхийн 10 хувьтай тэнцэх хэмжээний Ардкойныг барьцаалан Г.Хасбазартай барьцааны гэрээ, Ард Пропертиз ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Уянгатай батлан даалтын гэрээг тус тус байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгосугай.

4. Энэхүү санал хураалтад Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ГАНЗОРИГ